



Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, профессор **Бямбажавын Пүрэв-Очир**

Үгсийн цэцэрлэгч Бямбын Ринчен, түүний “Бэр цэцэг”-ийн баглаа, тэгээд “Хортобажийн аргал”-ыг нь шинжихүй дор...

Эр хүн эрэлхэг зоригтой байвал нэн эрхэм,
Эх орондоо шударга үнэнч байвал нэн сайхан.
Үлээхэд цаашаан, өрөвхийхөд наашаан болж,
Үзэлгүй бөөрөнхийгөөр хамжуулыг дууриагаачин.
Эцэстээ олны инээдэм, хүний доог,
Эх орондоо шившиг, түмэндээн гутамшиг.
("Б.Ринчен, "Эр хүн", 1957)

Смел и неустрашим всегда должен быть муж,
И в верности Родине его наилучшая красота!
А те, кто подаржают беспринципностью
перекати-полю,
Дохни и катятся туда, вдохни и катятся сюда-
Их удел печальный – презренье и насмешки,
И Родине они позор и народу они срам!
("Муж", 1957)

Их бичгийн хүн, эрдэмтэн-зохиолч Бямбын Ринчен гуайн шүлэг зохиолын сонгомол буюу анхны цоморлогийг МЗЭ-ээс эрхлэн **"Бэр цэцэг"** нэртэйгээр 1958 онд хэвлүүлжээ. Энэ номд Ринчен гуайн 1927 онд бичсэн "Сар" (Луна) шүлгээс өгсүүлээд, алдарт "Монгол хэл" (1957), "Бэр цэцэг" найраглал (1945-1955) тэргүүтэн яруу найргийн зохиолууд, мажаар яруу найрагч Петөөфи Шаандорын **"Интоорын жимс, мөчрөөс сайн чимхдэг байлаа"**-г хүртэлх орчуулга, нийтдээ 55 зохиолыг багтаасан буй.

Энэхүү **"Бэр цэцэг"** цоморлогийн редактораар Д.Тарваа гуайн нэр байдаг. Харин Ринчен гуайн шүлэг зохиолын анхны дэвтэрт МЗЭ-ээс нэг ч үг бичээгүй, редактор ч өмнөх үг цухуйлгаагүй, зохиолч нь өөрөө "Өмнөтгөл", "Оршил", "Номыг нээх үг" энэ тэрийг бичиж, тайлбарлаагүй, мэдээлээгүй нь сонин байдаг юм. Тэр үед гарч байсан яруу найргийн номуудыг ер нь Тарваа гуай **"редакторладаг"** байж. Томчууд Тарваа даргатайгаа жаахан үзэж тардаг байж л дээ...

Ринчен гуайн зохиолын сонгомлыг "Сар" (1927) шүлгээр нь эхэлж, улмаар **"Юуны магад"** (1932), ("Быть может"), **"Цаг ирвээс"**, 1933 ("Придет час") гэдэг бодрол бясалгалын хоёр тансаг эргэцүүлэл буюу одоогийн ярьж хэлж буй төрөл жанраар бол "эсээ-нийтлэл" маягийн уран сайхан таталбараар өрнүүлсэн нь номын "Өмнөтгөл", ёстой нөгөө "Оршлын оронд..." гэсэн

шиг маягийн зүйл болсон нь одоо бодоход сонин шийдэл байсан нь харагдаж байна.

"Цаг ирвээс" (1933) бол зохиогчоос өнгөрөн үргэлжилж буй орон-цагт өгүүлэн буй, бүтээл туурвилынхаа зорилго, зорилтыг уран сайхнаар тайлбарласан (одоогийнхоор бол тийм менежментийн зорилго чиглэлтэй гэмээр) **"Нар"**, **"Сар"**-ны гэрэлд хэлсэн үг-утгын цэцэрлэгчийн нээлтийн үг өгүүлбэр юм. **Тэр нь:**

Цаг ирвээс

Би цэцэглэгч бүлгээ. Цэцэглэгтээ сэтгэлийн яруу цэцгийг энхрийлэн ургуулнам билээ. Хүмүүний нүднээ үл үзэгдэх арвис илбийн тунгалаг өнгөт сэтгэлийнхээ цэцгийг төрсөн нутгийнхаа алтан наранд ээлгэж долгилогч зүрхнийхээ халуухан цусаар тордон ургууллаа би.

Хорт муу нүднээс энхрийлэнхэн хамгаалж, цэцэглэгт орох зам үүд хаалаа би. Гагц цаг ирвээс миний цэцэглэгийн хаалга өөсөөн нээгдэж, журамт амраг орогсдоо босгын өмнө бахданхан угтаж, хүжсийн үнэр анхилсан сэцэглэгтээ удирданхан оруулмуу би. Тэгээд сэцэглэг минь түмний цэнгэл баярын сэцэглэг болоюу.

Би санг хадгалагч бүлгээ. Сэтгэлийнхээ яруу эрдэнэсийг сандаа энхрийлэн хадгалнам билээ. Хүмүүний нүднээ үл үзэгдэх арвис илбийн хурц өнгөөр эрдэнэс минь гилбэлзэнхэн, алаг зүрхний минь гал улаан цус гялалзан байгаа нь тэр буюу. Муу нүднээс энхрийлэн хамгаалж, эрдэнэсийн санд орох зам үүдээ хаалаа би. Гагц цаг ирвээс миний эрдэнэсийн сангийн хаалга өөсөөн нээгдэж, журамт амраг орогсдоо босгын өмнө бахданхан угтаж, гялалзанхан гилбэгнэсэн эрдэнэсийнхээ санд удирданхан оруулмуу би. Тэгээд эрдэнэсийн сан минь, түмний түгээлийн сан болоюу.

1933.IX.9

Харин нөгөө **"Юуны магад"** (1932) нь бол ирээгүй цагт, магад чанарын дор эх орон, төрсөн нутаг, ард түмэн, багш нарынхаа ачий нь хариуланхан, юу хийж бүтээхээ сэтгэл зүрхний угаас уяран угтаж хэлсэн үг-утгын цэцэрлэгчийн төрөгдөл санаа-эсээ гэмээр санагддаг юм. Энэ нь:

Юуны магад

Гуч хүрээд, би сая тогтнолоо.

Кунз

Дөч хүрээд би сая тогтноюу. Тэгээд үгсийн цэцэрлэгч болж ч магад буюу. Тэгвэл сэтгэлийн гайхамшиг сайхан цэцэг зүрхнийхээ улаан цусаар ургууланхан, намайг хүн болгосон эх орондоо анхилмал үнэрээр нь ачий нь магтан хариулаюу.

Цаст уулын оргилоос цагаан болоюу, толгой минь. Тэгээд, мөнх билгийн налина лянхуа цэцэг, сэтгэл зүрхэнд минь дэлгэрэнхэн цэцэглэж магад буюу. Тэгвэл, гайхамшигт сайхан цэцгийн анхилмал үгээр, намайг сурган хүмүүжүүлсэн Багш нарынхаа ачий нь магтан хариулаюу.

Сэтгэл минь гүн нуураас амгалан болоюу. Тэгээд үгсийн уран бүтээлч болж ч магад буюу. Тэгвэл, сэтгэлийнхээ чин үгээр хүсэн сэтгэхүйн гайхамшигт сайхан орд босгон, гялалзсан үзэсгэлэн гоогоор нь төрсөн нутаг, ард түмэндээ ачий нь магтан хариулаюу.

Санаа сэтгэл минь одооныхоос сайхан болоюу. Тэгээд, үгсийн уран барималч болж ч магад буюу. Тэгвэл, сэтгэл зүрхнийхээ нандин бодлын гантигаар хүсэн сэтгэхүйн гайхамшигт хөрөг бүтээн босгож, дур булаам арвисын үзэсгэлэнгээр нь, ард түмнийхээ ачтан хөвүүдийн ачий нь магтан хариулаюу. 1932.2.10.

Ринчен гуайн **“Бэр цэцэг”** шүлэг зохиолын түүвэр-цоморлогийн урд хожид давтагдаагүй нэгэн сонин онцлог бол энд багтан орсон бүх шүлэг, найраглал, эсээ-нийтлэлийг оросоор зохион, зэрэгцүүлэл хийсэн явдал юм. Энэ нь эрдэмтэн-зохиолчийн хэл соёлын гарамгай ур чадвар, өндөр дээд боловсрол, үлэмж авьяас билигтэйн илрэл, нөгөө талаар, монголын зохиолчдод шинэ алхам, том туршлага болж үлдсэн юм. Тухайлбал, “Юуны магад”-д:

...Цаст уулын оргилоос цагаан болоюу, толгой минь. Тэгээд, мөнх билгийн налина лянхуа цэцэг, сэтгэл зүрхэнд минь дэлгэрэнхэн цэцэглэж магад буюу. Тэгвэл, гайхамшигт сайхан цэцгийн анхилмал үгээр, намайг сурган хүмүүжүүлсэн Багш нарынхаа ачий нь магтан хариулаюу... гэдгийг: Орос эх дээр нь:

...Белее вершин снежных гор будет голова моя.

И, быть может, тогда Налина-лотос-цветок вечной Мудрости расцветет в сердце моем и благоуханьем чудесных слов воздам я хвалу меня наставлявшим Учителям...

гэж, өндөр дээд найруулгаар, тансаг сайн үг өгүүлбэрээр орчуулан хэлсэн байдаг.

Ийнхүү үгсийн цэцэрлэгчийн үг буюу **“Цаг ирвээс”, “Юуны магад”** хэмээх хоёр эсээ-бодролоор **“Бэр цэцэг”** хэмээх шүлэг зохиолын цоморлогийн үүдэн хаалга өөсөөн нээгдэж буй

юм. Энэхүү хаалганы хүндтэй босгыг алхан орвоос **“Бэр цэцэг”**-ийн баглаанд:

1) Улс түмнүүдийн энх тайван, найрамдал, хүмүүсийн сайн харилцаа, соёл хоорондын холбоо, хүн ба байгалийн үнэт зүйлийг дээдлэх сэдэв, чиглэлтэй:

“Н.Тихоновт”, М., 1947 (“Н.Тихонову”),

“Үдэш Невскийд”, Л., 1947 (“Вечером на Невском”),

“Нева мөрөн”, Л., 1947 (“Нева”),

“Горькийн гудамжинд”, М., 1947 (“На улице Горького”),

“Хамжлага эр”, Мажар, 1947 (“Раб”),

“Москвад баяр хүргэе”, М., 1947 (“Привет Москве”),

“Бид энхийн төлөө”, 1949 (“Мы за мир!”),

“Улс түмнүүдийн зориг агуу, гайхамшиг”, 1950 (“Могуча и непобедима воля народов”),

“Зөвлөлтийн эмч нарт”, 1955 (“Советским врачам”),

“Джордано Бруно”, 1956 (“Джордано Бруно”),

“Хосбаяр”, М., 1956 (“Двойная радость”),

“Баатадын талбайд”, Будапешт, 1956 (“На площади героев”),

“Геллерт ууланд”, Буда хот, 1956 (“На горе геллерт”),

“Хортобаажийн аргал”, Будапешт, 1956 (“Хортобадский аргал”),

“Бэр цэцэг”, 1945-55, (“Цветок невесты”),

“Тыны сүмд”, Праг, Словак буудал, 1956 (“В Тынском храме”),

“Нөхөддөө мэнд хүргэе!”, Праг, 1956 (“Привет друзьям!”),

“Шидэт толь”, Братислав, Девин буудал, 1956 (“Волшебное зеркало”),

“Тиан Жүү Тан”, Пекин, 1957 (“Тяньчжутан”),

“Нисэх онгоцноос үзхүл...”, Нисэх онгоцноо, 1957 (“С птичьего полета”),

“Таван жил үү, таван мянган жил үү?”, Бээжин, 1957 (“Пять или пять тысяч лет?”),

“Намрын өвсний шивнээ”, Ордос, 1957 (“Шепот осенних трав”),

“Бээжин махагалын сүм”, Пекин, 1957 (“Храм махакалы в Пекине”),

“Хот айлд Октябрь”, 1957 (“Октябрь в стойбище”) гэх зэрэг 20 гаруй шүлэг зохиол байна. Эдгээрийг Ринчен гуай гол төлөв гадаад оронд ажлаар явахдаа бичсэн, орос-монголоор зохиосон нь сонин бөгөөд “Том том зочид буудалд тухлавч зүгээр суудаггүй, цагийг алтнаас эрхэмд үздэг тийм их бичгийн хүн, тийм өндөр соёлтон байсан”-ыг харуулдаг.



Өөрөөр хэлбэл, 1947-1957 оны хоорондох 10 жилд гадаад орнуудаар зочилж юм үзэж, нүд тайлж, ухаан бодлоо уралдуулж, гадаад ертөнцөд тоогдож явахдаа Москва, Ленинград, Будапешт, Праг, Братислав, Бээжин, Буда хот, Хөххот, Ордост бичсэн, бүр зарим нь нисэх онгоцноо бичсэн-орчуулсан шүлгүүд байгаа нь өвөрмөц юм. Жишээлбэл, **“Таван жил үү, таван мянган жил үү?”** (Бээжин, 1957) шүлэгтээ:

Айл зэргэлдээ хоёр улсын соёлын харилцааны сударт

Ард шинэ Монгол, чөлөөт шинэ Дундат улс шив шинэхэн.

Нэгэн хуудас нээн сөхсөний таван жил одоо болжээ.

Нэг таван жилээр ч барахгүй, таван мянган жилээс наашгүйдэг.

Түүхийг бүтээсээр ирсэн жирийн хүн ардын үүсгэж зохиосон

Түмэн сайхан уламжлалт манай соёл, найрамдлын судар.

хэмээн бичиж үлдээсэн буй. Энэ шүлгийн орос эхийг үзхүл, Ринчен гуай **“судар”** гэдгийг “книга” гэдэг үгээр, ер “судар номын хэл” гэдгийг “книжный язык” гэдгээр оноон тохоож хэлдэг нь их сонин бөгөөд мэдмээр зүйл байдаг.

2) Ринчен гуайн **“Бэр цэцэг”**-ийн цоморлогийн нөгөө нэг чухаг сэдэв, чиглэл нь эх орон, монгол хүн, үндэсний түүх, ёс заншил, эх хэл бичиг, утга соёлын асуудал юм. Эх оронч найрагчийн энэ чиглэлийн шүлэг зохиолд:

“Сар”, 1927 (“Луна”),

“Хээр, намар”, 1947 (“Осень в степи”),

“Улсын маань далбаа”, М., 1947 (“Наш флаг”),

“Бүл сайтай шүү, бид!”, 1956 (“Нас много”),

“Сайн зуршил”, 1957 (“Хороший обычай”),

“Хубилай сэцэн”, 1957 (“Хубилай мудрый”),

“Намрын өвсний шивнээ”, 1957 (“Шепот осенних трав”),

“Эр хүн”, 1957 (“Муж”),

“Монгол хэл”, Хөххот, 1957 (“Монгольский язык”) зэрэг хэдэн шүлгийг хамааруулж болмоор байна.

Цогтой эх оронч, их бичгийн хүн Ринчен гуай **“Улсын маань далбаа”** (1947) шүлэгтээ **“Төрийн”** гэдэг үг хэрэглээгүй, харин **“Улсын маань далбаа”**, **“Эх орондоо хайртайн санаа”**, **“Дархан мөнхийн тэмдэг!”** гэдэг нийлэмжийг онцолсон байдаг. Эхний бадгийг монгол-оросоор нь сонирхож үзвэл:

Улсын маань далбаа

Улаан, хөх, улаан нь:

Эрх чөлөөний маань

Давхар их баяр.

Эх орондоо хайртайн санаа

Дархан мөнхийн тэмдэг!

Синий, красный, синий –

Флага нашего цвета, -

Цвета радости двойной: -

Символ верности бессмертной,

Нашей Родине любимой,

Верности свободе знак!

хэмээн ойлгомжтой, утга төгөлдөр, тэгээд бас шүлгийн холбоц нэхээсийг машид нарийн гаргаж хэлсэн байна.

Ийнхүү **“Бэр цэцэг”**-ийн баглаанаас цэцэгсийг нэг нэгээр нь сугаланхан ажиглаж болох, бас өчүүхэн боловч, танихуйн шинжтэй задаргаа, тайллыг хийж болох. Чингэвээс уншигч, судлаач та бидэнд ховордсон, олдохгүй болсон энэ ном, шүлэг зохиолууд дахин амилсан мэт болж юуны магад аа. Энэ удаад **“Хортобажийн аргал”**-ыг авч, Ринчен гуайн шүлэг найргийн галын дэргэд сууж, хэдэн өгүүлбэр хүүрнэвэл ямар вэ? гэж шийдэв. Бидний тавьсан зорилго ч тийм бөгөөд **“Хортобажийн аргал”**-ыг шинжихүй дор... гэсэн билээ. Юуг шинжиж болохсон билээ?!

Монгол эх нь:

“Хортобажийн аргал”

Хөх Дунай жавхлантай, хөгжилт Будапешт, гандарисын балгас мэт сайхан аа!

Хуайшу модны цэцэг энд, хурц үнэр хавар ханашгүй гоё гэнэм билээ.

Эвий, агаарын хий нь тэрэгний бензин, элдэв үйлдвэрийн өмхий утаа ханхлан,

Таатай сайхан цэцэг мод хүртэл тайзын чимэглэл мэт зун чиг үнэргүй нь хачин.

“Дунай” буудалд, дотор бачимдан дурлам гудамжид ч амьсгал бүтээд,

Манай хөдөө нутагтай ав адил, маш нарлаг боловч, агаар, агаар дутнам!

Хортобажийн хөдөө талд нь ховор эрдэнэ олсон мэт баярланхан,

Ар монгол нутагтай эгээ адилхан, агь ханхалсан аргал олж өвөртлөөд,

Үдэш нь Дунай гэдэг их буудалдаа үнсний саванд утаа тавин асаадаг боллоо.

Багын дадсан аргалын тэр утаа, бахтай таатай, агийн үнэрт нь хамар загатнанхан,

Энхэр монгол тал нутгийн минь үнэр л энэ тасалгаанд ханхлах мэт сайхан санагдлаа. Будапешт, Дунай буудал, 1956.IX.23

Орос эх нь:**“Хортобадский аргал”**

Словно град Гандарис прекрасен Будапешт и величав голубой Дунай,

И акаций цветы, говорят, невиданно благоуханны здесь весной, Но воздух летом дышит гарью бензиновой и дымом фабрик и заводов,

И словно декорации театральные не пахнут тут цветы и деревья.

И душно мне на улицах красивых, душно в комнате гостиницы “Дунай”

Солнце здесь, как у нас в степи, но воздуха, нет и нет!

В степи Хортобадской подобрал я, как драгоценность редкую.

Кусочек аргала, что пах еще полынью, совсем, как у нас в степи

И вот он горит вечерами в моей огромной гостинице “Дунай”,

Щекочет ноздри мой знакомый запах полынный, такой мне милый,

И словно степью монгольской веет на меня здесь в комнате моей! 1956.IX.23 Будапешт, Отель Дунай

А) 60-70-аад оны үе юм даа. “Ринчен гуай гэж нэг их эрдэмтэн-зохиолч байдаг гэнэ. Тун их үндэсний үзэлтэй хүн юм гэнэ ээ. Гадаад улс оронд явахдаа Монголоосоо аргал, хомоол авч явдаг. Тэгээд буусан суусан буудалдаа уугиулан, аргалын утаа үнэртэж суудаг гэнэ. Тэгэхгүй бол эх орноо санаад сууж чаддаггүй юм байх.” гэх ухааны домог ч юм шиг, ортой ч юм шиг, оргүй ч юм шиг зүйл чих дэлсдэг байж билээ. Гэтэл энэ нь хожмоо бодоход, 1956 онд бичиж нийтлүүлсэн нөгөө **“Хортобажийн аргал”**-аас үүдэлтэй, ам дамжсаар арай л хэтийдсэн цуу үг, цуурай үг байж л дээ. Харин тэгээд мартаж боломгүй зүйл нь энэ мэт шүлэг, зохиолоор нь айлган далайлгаж, Ринчен тэргүүтэн тэр цагийн тэргүүлэх сэхээтнүүдийг үзэл суртлын лантуугаар балбаж, “үндсэрхэх үзэлтэн” хэмээх нэр хаяг өгч, зохиол бүтээлийг нь цензүүрдэж гуйвуулан тайлбарлаж байсан явдал юм.

Б) Сэдвийг бодож олсон хийгээд үүтгэл санааг эх бичвэрийн агуулгад нийцүүлэн бодож олсон нь сонин юм. Аргалчин хүн хөдөө хээр талаас нэг сайхан том хөх аргал олох лугаа адил зохиолч хүн соёл иргэншлийн дундаас нэг сэдвийг олж, суурин ба нүүдлийн хоёр өөр соёл иргэншлийн зааг дээр шинэ санааг ургуулан бодсон нь:

Хөх Дунай жавхлантай, хөгжилт Будапешт, гандарисын балгас мэт сайхан аа!

Хуайшу модны цэцэг энд, хурц үнэр, хавар ханашгүй гоё гэнэм билээ.

Эвий, агаарын хий нь, тэрэгний бензин, элдэв

үйлдвэрийн өмхий утаа ханхлан,

Таатай сайхан цэцэг мод хүртэл, тайзын чимэглэл мэт, зун чиг үнэргүй нь хачин.

“Дунай” буудалд, дотор бачимдан, дурлам гудамжид ч амьсгал бүтээд,

Манай хөдөө нутагтай ав адил, маш нарлаг боловч агаар, агаар дутнам!

Хортобажийн хөдөө талд нь ховор эрдэнэ олсон мэт баярланхан,

Ар монгол нутагтай эгээ л адилхан, агь ханхалсан аргал олж өвөртлөөд...

гэж шүлэгт амилсан юм.

В) Шүлгийн энэ хэсгийн санааны бүтцийг ажваас, үг-утгын цэцэрлэгчээс орон-зай, цаг хугацааны тодорхой хэрчим дээр бодит байдлын зарим зураг дүрийг харж мэдэрсэн, зарим дүрийг дамаа сонсож мэдэрсэн, бүр зарим дүр-шинжийг нь ухааж бодож танин мэдсэн тийм байдлаар бичиж дүрсэлсэн гэж үзэв. Тухайлбал,

“Хөх Дунай жавхлантай, хөгжилт Будапешт, гандарисын балгас мэт сайхан аа!”

Словно град Гандарис прекрасен Будапешт и величав глубокой Дунай...

гэж найрагч өөрийн нүдээр харж мэдэрснээр:

Хуайшу модны цэцэг энд, хурц үнэр, хавар ханашгүй гоё гэнэм билээ.

И акаций цветы, говорят, невиданно благоуханны здесь весной...

гэж бусдын үг ярианаас сонсож мэдэрснээр буюу “хөндлөнгийн оруулбар” өгүүлбэрээр;

Гэтэл дараагийн мөрнөөс нүүдлийн соёл иргэншилт зохиолчийн сэтгэл хөдлөл, үнэлэмж өөрчлөгдөн, утга санааны эргэлт болох сацууд түүнийг **“Эвий”** гэдэг аялга үгээр эвтэйхэн зөөлөн, гэхдээ чамлангүй сөрөг үнэлэмжээр илэрхийлэн, санаагаа ахиулж байна. Тэр гоё хэсэг нь:

...Эвий, агаарын хий нь, тэрэгний бензин, элдэв үйлдвэрийн өмхий утаа ханхлан,

Таатай сайхан цэцэг мод хүртэл, тайзын чимэглэл мэт, зун чиг үнэргүй нь хачин.

“Дунай” буудалд, дотор бачимдан, дурлам гудамжид ч амьсгал бүтээд,

гэжээ.

Энд шүлгийн (эх бичвэрийн) хэлбэр-хэлзүйн бүтэц, учирзүйн бүтэц, утга санааны бүтэц, үүрэг-мэдээллийн бүтцэд **“...агаар агаар дутнам”** (...но воздуха, нет и нет) гэсэн хүчлүүлэх утгат давталтыг хийж, онцолсон нь зохиолч одоо л өөрийн санааг шургуулах, “аргалын утаа”, нүүдэлчний соёл сэтгэлгээний үнэлэмжээ уран сайхнаар хэлж өрнүүлэх тийм шийдлийг бий болгож байна. Тэгэхлээр Ринчен гуай эх бичвэрийг монголоор ч, оросоор ч маш сайтар бодож шүлгийн зохиомжийг олсон нь харагдаж



буй билээ. Энэ нь шүлгийн **төгсгөл хэсэг** болох:

Ар монгол нутагтай эгээ адилхан, агь
ханхалсан аргал олж өвөртлөөд,

Үдэш нь Дунай гэдэг их буудалдаа үнсний
саванд утаа тавин асаадаг боллоо.

Багын дадсан аргалын тэр утаа, бахтай таатай,
агийн үнэрт нь хамар загатнанхан,

Энхэр монгол тал нутгийн минь үнэр л энэ
тасалгаанд ханхлах мэт сайхан санагдлаа.

гэсэн энэ хэсэгт нүүдлийн соёл иргэншилт, тал
нутгийн монгол найрагчийн үгээр улам лавширч
байна.

Д) Шүлгийн төгсгөл хэсэгт үндэсний онцлогтой
үг-хэллэгийг олонт хэрэглэсэн, тэр чанараараа
шүлгийн **эхний хэсэг, төгсгөл хэсэг** хоёр нь
утга санаагаараа эсрэг хэлхэцийн шинжтэй болж,
урансайхны дүрслэлийн талаасаа бие биеийг
тодруулж, өнгө ялгаж буй мэт болсон. Чингэхдээ
"тамхины үнсний сав", "утаа" гэдгээс тойрч, орос
шүлэгтээ ямар сайхан тансаг найруулгын үг
хэллэгийг хэрэглэснийг одоо харъя. Үүнд:

В степи Хортобадьской подобрал я, как
драгоценность редкую.

Кусочек аргала, что пах еще полынью, совсем,
как у нас в степи

И вот он горит вечерами в моей огромной
гостинице "Дунай",

Щекочет ноздри мой знакомый запах
полынный, такой мне милый,

И словно степью монгольской веет на меня
здесь в комнате моей.

Эцэст өгүүлэх минь, **"Хортобаажийн аргал"**-
ыг шинжихүй дор,

- Мөнгөн буурал тэргүүнтэй, хүрэн тэрмэн
дээл дээрээ мөнгөн тоногтой суран бүс бүсэлсэн,
нүүдлийн ба суурин хоёр соёл иргэншлийн их
эрдэм боловсролтой тэр монгол зохиолч, их
бичгийн хүн "Хортобаажийн тал нутаг"-аас нэгэн
аргалыг авч, сонины цаасанд боон, үл мэдэг
инээмсэглэн, өвөртөлж буй дүр төрх харагдана.

- Шүлгийн сэдэв, зохиомж, хэлбэр нь ер
энгийн дүү шиг боловч, энэтхэг-европын яруу
найргийн (шүлгийн) уламжлалыг айхавтар
тооцсон, санааны болон мэдээллийн бүтцийнх
нь дотоод хөтөлбөржилт машинд нарийн, зохист
аялгууны хуулийг чанад мөрдсөн, сул үгийн
хивэггүй тийм тансаг найруулгаар бүтээсэн
харагдаж байна.

- Энхэр монгол тал нутаг, эх орондоо сэтгэл
зүрхнээсээ хайртай тэр үгсийн цэцэрлэгчийн
үндэсний бахархлын учир магад чанарын дор,
түмний төлөө өгүүлсэн шүлэг гэмээр санагдана.
Тиймийн учир, өвгөн бичээч, өтгөс Бямбын Ринчен
гуай "Цаг ирвээс" ("Придет час", 1933)-ийгээ: **"И
будет сокровищница моя общей радостью
тысяч и тысяч."** хэмээх өгүүлбэрээр өндөрлөсөн

байдаг билээ л. Энэ үгээр л би ч гэсэн судалбараа
өндөрлөө, байз!

"Бэр цэцэг" шүлгийн номд сонирхолтой
олон үүсмэл үгийг хэрэглэсэн. Тэр нь Ринчен
гуайн "Би санг хадгалагч билээ" гэдэг санаанд
тохирч нийцсэн байдаг бөгөөд тэдгээр үүсмэл
үг нь монгол хэлний үгийн санг баяжуулсан
байдаг. Тийм үгсийн нэг бол **"Хортобаажийн
аргал"**-д буй "Энхэр монгол нутгийн минь үнэр,
энэ тасалгаанд ханхлах шиг..." гэдгийн **"энхэр"**
болой.